

## ХЯТАДЫН ЦАЙНЫ СОЁЛ

Ч.ТААМАА\*

Цай бол хятад үндэстний гол ундаа юм. Хятад судлаачид цайны ургамлыг тарих, боловсруулах, хэрэглэх бүхий л соёл нь хятадаас гаралтай гэж үздэг. Судлаачид цайг анх Шэнь Нуны үеэс үүсэлтэй гэж үздэг. Улмаар Жоу улсын үед цайны хэрэглээ хөгжих сууриа тавьж Тан улсын үед өргөжин тэлж Сүн улсын үед улам боловсронгуй болж ирсэн бөгөөд дэлхий нийтээрээ хэрэглэдэг гурван том спиртгүй ундааны нэг болтлоо өргөн хэрэглэдэг болсон. 21-р зуунд цай нь ундааны их хаан болсон бөгөөд цайг дэлхийн бүх улсын 50-иас илүү нь тариалдаг болжээ. Улмаар дэлхийн улс бүр хамгийн түрүүнд цайны навч ууж, цайны үрийг тариалж, цай уух арга, ургуулах технологийг боловсруулах, цайны ёс заншил зэрэг нь Хятад улсаас дам дамжин тархсан. Хятад улс дэлхий дээр хамгийн түрүүн цайны модыг нээж, ургуулж, ашигласан орон гэж хятадын цай судлаачид үздэг.

Хятадын цайны соёл бол Хятадын цай чанах, түүнийг хэрэглэх соёл юм. Цай нь хятад хүний өдөр тутмын хэрэглээний долоон зүйлийн нэгэнд ордог билээ.<sup>2</sup> Хятадын цайны соёл нь Европ, Америк, Японы цайны соёлоос маш их ялгаатай. Цайны соёл нь урт удаан жилийн түүхтэй, материаллаг соёлын давхаргыг агуулах төдийгүй гүн гүнзгий агуулгатай оюуны соёл иргэншлийн шат

дарааллыг илэрхийлдэг. Тангийн үед эрдэмтэн Лю Юй цай судлалын түүхэнд хятадын цайны соёлын бүрээг үлээсэн. Үүнээс хойш цай нь хааны ордон, нийгэм, шүлэг уран зураг, яруу найраг, шашин анагаах ухаанд гүнзгий нэвтэрсэн. Хэдэн мянган жилийн туршид цайг тариалж үйлдвэрлэж, боловсруулах материаллаг соёлыг бий болгож, улмаар цайны талаар маш баялаг оюуны соёлыг хуримтлуулсан, энэ нь Хятадын онцлог бүхий цайны соёл бөгөөд соёл судлалын хүрээнд авч үздэг болжээ.

Эртний Чэн Ханы түрүү үед Хятадын Сычуаны бүс нутгаар цай уух соёл анх дэлгэрч байсан. Баруун Ханы үед цай бол Сычуаны онцгой бүтээгдэхүүн болсон байна. Хятадын эртний Сычуан бол цайны модны өлгий нутаг бөгөөд энэ газар 3 их хаан хаан амьдардаг байсан гэсэн домог яриа байдаг.

3 их хаан бол Хятадын Сиа гүрний түрүү үеийн домог ярианаас үүссэн эзэн хаад юм. Тэд цөм овог аймгийн тэргүүлэгчид байсан. Үүний нэг нь Шөн Нун юм.

Шөн Нун буюу газрын сахиус бол эртний үе дэх газар тариалан, эм зүй, анагаах ухааныг үүсгэгч юм. Домог ярианд түүнийг үхэр толгойтой хүн биетэй байсан гэж ярьдаг. Хан улсын үед "Газар тариалагийн ургамлын сударт тэмдэглэсэнээр: "Шөн Нун 100 өвс ногоог амталж, тэдгээрийн шинж байдал,

\* Ч.ТААМАА- МУИС-ийн Гадаад хэл соёлын сургуулийн багш, доктор, профессор

ач холбогдлыг олж тогтоодог байсан бөгөөд өөрийн биеэр туршин шинждэг байжээ. Нэгэн өдөр 72 дахь ургамалд хордон улмаар цайны ургамлаар хороо тайлж болохыг олж мэджээ хэмээжээ. Ард иргэд Шөн Нуны өвс ногоог амталсан талаар ярихдаа: Шөн Нун бол усан болор шиг тунгалаг гэдэстэй, ямар зүйл идсэн байсан ч хүмүүс түүний ходоодон доторхыг харж болдог байсан гэнэ. Тэр үеийн хүмүүс юм идэхдээ бүхэл хахлаар залгидаг байсан учраас байнга өвддөг байсан. Шөн Нун хүмүүсийн зовлон зүдгүүрийг арилгах аргыг олохын тулд ургамлыг бүгдийг нь амталж туршиж үзээд эдгээр ургамлыг гэдсэн дотроо яаж өөрчлөгдөхийг сайтар хардаг бөгөөд аль нь хортой аль нь хоргүйг магадладаг байв. Тэр нэг төрлийн цагаан цэцэгтэй байнга ногоон байдаг модны зулзаган навчыг амтлах үед гэдсэн дотор дээрээс доошоо, доороос дээшээ хаа сайгүй урсан угааж байв, яг л гэдсэн дотор нэг юм шалгаж байгаа мэт, иймээс тэр ногоон навчийг “шалгах” “查” хэмээн нэрлэсэн. Үүний дараа хүмүүс “шалгах”-ыг “цай” хэмээн нэрлэдэг болсон. Шөн Нун удаан жил урт хугацаагаар уулыг давж усыг гатлан, элдэв янзын өвс ногоо амтлан өдөр бүр хэдэн удаа хортой таарч, цайгаар хорыг тайлж байжээ. Нэг удаа Шөн Нун хортой өвсөнд хорджээ. Цайны навчаа идэж амжилтгүй хордож үхсэн байна. Хойч үе нь газар тариалан, анагаах ухааныг үүсгэн байгуулагчийн гавьяа зүтгэлийг дурсаж, өдгөө ч гэсэн өвс ногоо амталдаг Шөн Нуны ийм нэгэн домгийг уламжлан ярьсаар байна.

Хятадын цайны соёл бүрэлдэн тогтсон нь

1. 3 улсын түрүү үед маш олон ном сударт цайны үүслийн талаар бичиж тэмдэглэсэн байдаг бөгөөд (МЭӨ 2737-2697 онд), 3 их

хааны домгийг гаргаж ирсэн. Зүүн Хан улсын Хуа Түо-гийн /идээний сударт/ “гашуун цайг байнга хэрэглэх нь ихээхэн ашиг тустай байдаг гэсэн” цайны талаар анагаах ухааны үнэ цэнэтэй зүйлийг тэмдэглэсэн байдаг. Баруун Хан улсын үед цайг тариалдаг тосгоны “茶陵” хэмээн нэрлэдэг байжээ. Улмаар Хятадын өмнөд болон баруун өмнөд хэсгийн нутгийг цайны төрөлх нутаг гэх бөгөөд баруун өмнөд нутгуудаар Сычуан, Юннань, Гүйжоуд зэрлэгээр цайны модыг анх удаа тариалдаг байсан тухайд судлаачид санал нэгтэй байна. 3 улсын үеийн “Туан Яа” бүтээлд бинтэй цай хийх, хэрэглэх аргыг тэмдэглэсэн байдаг.

2. Жин болон Нань Бэй улсын үед бичгийн хүмүүс цайтай холбоотой шүлэг, дууны үг тэрлэх явдал өдрөөс өдөрт ихсэж, цай уух хэв маяг нь нэгэн төрлийн соёл болон хөгжсөн.

3. Тан улсын үед цайг хэрэглэх явдал ихэд дэлгэрч нийгмийн бүх давхрагын хүмүүс өдөр тутмын ундаандаа хэрэглэх болсон, хүн ам өссөний улмаас үр тариа хомсдож архи эсгэхэд зарцуулдаг тариаг хэмнэх үүднээс Су Зун хаан архи хийхийг хориглосон ингэснээр архийг орлуулан цайг ихээр хэрэглэх болсон. Тан улсын үед шүлэг яруу найраг цэцэглэн хөгжиж цайгаар өргөл барьц барих нийтлэг болжээ. Цай нь бичгийн хүмүүст ихэд таашаагдсан бүтээл туурвилынх нь нэгэн сэдэв болсон байна. Цайны тухай олон арвин бүтээл зохиогдон гарч ирэх болсон. Тухайлбал цайны эцэг хэмээн алдаршсан Лю Юй-ын бичсэн цайны судар нь цайны мод навч тарих, чанах, уух арга болон туршлагыг дүгнэн өгүүлсэн байна.

4. Сун улсын үед цайны аж ахуй маш их хөгжсөн нь цайны соёлын хөгжилд түлхэц болсон, бичгийн хүмүүсийн дунд цайны бүлгэм байгуулан, ордонд цайны хэрэг эрхлэх

газар байгуулагдсан бөгөөд ойр дотны ноёд түшмэл, элч төлөөлөгчдийг урьж цайгаар дайлдаг байжээ. Энэ нь эзэн хаан албатуудаа өөртөө татах нэгэн арга байсан гэж үздэг. Энгийн ардуудын дунд цайны соёл ихээхэн дэлгэрч нэг нэгэндээ цайг бэлэглэдэг болов.

5. Мин улсын үед цайг боловсруулах арга технологи улам боловсронгуй болж түүнийг хатаах, жигнэх, хуурах аргаар боловсруулах болсон төдийгүй цайны хэрэглээ улам ихэссэн. Цайны гол түүхий эд нь ногоон болон цэцэгт цайны ургамал байв.

6. Чин улсын цайны хэрэглээ урьд өмнө байгаагүйгээр өргөжсөн. Энэ үед ногоон цэцэгт цайнаас гадна улаан, хар, цагаан зэрэг цайны үндсэн төрөл зүйлүүд бий болсон төдийгүй цай хүний өдөр тутмын амьдралын хэрэглээ болсон.

7. Хятадын цай үйлдвэрлэлийн хэмжээ 1 сая 400 мянган тонн хүрч дэлхийд нэгдүгээр байр эзэлсэн. Цайны үйлдвэрлэл өссөнөөр Хятадын цайны соёлын хөгжлийн үндэс суурь улам бэхэжжээ. 1982 онд Ханжоуд хамгийн анх цайны соёлыг нэмэгдүүлэх зорилготой "Цайчдын гэр" гэсэн нийгмийн бүлгэм байгуулагдаж, 1983 онд Хубэйд "Лю Юйгийн цайны соёлыг судлах нийгэмлэг байгуулагдсан, 1990 онд "Цайчдын эвлэл" Бээжинд байгуулагдсан, 1993 онд "Хятадын олон улсын цайны соёлын судалгааны хүрээлэн Хужоуд байгуулагдсан. 1991 онд Хятадын цайны музей Ханжоугийн баруун Ху шианд албан ёсоор нээгдсэн. 1998 онд Хятадын олон улсын энх тайвны цайны харилцааны алба байгуулагджээ. Цайны хөгжил цэцэглэлтийг дагаад газар бүр цайны соёлын газар олноор байгуулагдаж олон улсын цайны соёлын судалгааны хурал 5 дахь удаагаа хуралдаж Япон, Солонгос, Америкийн

судлаачид оролцов. Аймаг, хот бүрт "Цайны баяр" зохион байгуулагддаг болсон бөгөөд энэ нь хятадын эдийн засгийн худалдааны хөгжилд чухал нөлөө үзүүлж байна.

### Дүгнэлт

1. Цай нь одоогоос 4000 гаруй жилийн өмнө үүссэн. Энэ нь эмийн журмаар хэрэглэж эхэлсэн үе бөгөөд харин цайг ундаа болгон хэрэглэсэн нь 2000 жилийн түүхтэй гэж судлаачид үздэг байна.

2. Цайны үүсэл гарлыг тухайлан судалж судар бичиг ном зохиолд оруулан тайлбарласан бүтээлүүд нь өнөөгийн цайны соёл, урлаг болтлоо хөгжихөд ихээхэн түлхэц болсон байна.

3. Цайны үйлдвэрлэл соёл болтлоо хөгжихөд хүн амын суурьшмал амьдрал, газар тариалангийн эрхлэлт, цаг уур зэрэг нь ихээхэн нөлөөлсөн гэж үзэж байна.

4. Тан улсын үеийн эрдэмтэн, цай судлаач Лю Юйгийн бичсэн судалгаанаас харахад цай нь эдүгээ 1800 гаруй жилийн түүхтэй гэж үзсэн байна.

### НОМ ЗҮЙ

1. Лю Юй "Цайны судар", Наньжиний "Пэн Хуан" хэвлэлийн газар 2007
2. Чэн Юньфэй "茶艺百科知识手册" Шаньдун 2006 он.
3. "神农本草经" буюу /газар тариалангийн сахиусын ургамлын судар/
4. Хуа Түо "Идээний судар" /食经/
5. Жоу Диан, Жиэ Жан Хуань "中国文化史三百题" Шанхай, 1998 он.
6. Гүо Жи Лиан "速成汉语初级教程" Бээжингийн хэл, соёлын их сургууль 1996.
7. Ию Ань, Хао Гөн "中国茶艺" Шаньдуны шинжлэх ухааны хүрээлэнгийн хэвлэлийн газар. 2004.